




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН  
ХЭЛТЭС



# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

## 2024 IX



[www.1212.mn](http://www.1212.mn)



Улаанбаатар хот  
2024 он

### I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

### II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- \* урьдчилсан гүйцэтгэл
- \*\* дахин










**III.** Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

### IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000		
сая	=10 <sup>6</sup>		
тэрбум	=10 <sup>9</sup>		
их наяд	=10 <sup>12</sup>		
мян	мянга		
%	хувь		
мм	миллиметр		
см	сантиметр		
дм	дециметр		
м	метр		
км	километр		
м <sup>2</sup>	метр квадрат		
дм <sup>2</sup>	дециметр квадрат		
км <sup>2</sup>	километр квадрат		
м <sup>3</sup>	метр куб		
га	гектар		
мл	миллилитр		
л	литр		
г	грамм		
кг	килограмм		
цн	центнер		
т	тонн		
Вт	ватт		
кВт.ц	киловатт цаг		
кал	калори		
ккал	килокалори		
Гкал	гигакалори(=10 <sup>9</sup> калори)		
с	секунд		
мин	минут		
мкг/м <sup>3</sup>	микрограмм метр куб		
м/с	метр секунд		
ш	ширхэг		
х.д.х	хэвлэлийн	даралтат	хуудас



## ГАРЧИГ

	ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2020-2024 ОН	1
	ЭРҮҮЛ МЭНД	2
	НИЙГМИЙН ДААТГАЛ	6
	ХАЛАМЖ	9
	ГЭМТ ХЭРЭГ	11
	ДҮҮРГИЙН ТӨСӨВ	16
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	20
	АЖ ҮЙЛДВЭР	25
	ЗАХИРГААНЫ МЭДЭЭ	31

ХҮСНЭГТ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Шинээр төрсөн хүүхэд		хүн	3 596 <span style="color: green;">↑5.9</span>	3 686 <span style="color: green;">↑2.5</span>	3 578 <span style="color: red;">↓2.9</span>	3 737 <span style="color: green;">↑4.4</span>	3 458 <span style="color: red;">↓7.5</span>
Халдварт өвчнөөр өвчлөгчид		хүн	864 <span style="color: red;">↓49.9</span>	25 017 <span style="color: red;">↑29*</span>	24 978 <span style="color: red;">↓0.2</span>	1 722 <span style="color: red;">↓93.1</span>	1 473 <span style="color: red;">↓14.5</span>
Бүртгэгдсэн гэмт хэрэг		тоо	1 252 <span style="color: red;">↓27.4</span>	1 406 <span style="color: red;">↑12.3</span>	2 232 <span style="color: red;">↑58.7</span>	2 783 <span style="color: red;">↑24.7</span>	3 521 <span style="color: red;">↑26.5</span>
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		хувь	0.7 <span style="color: green;">↓0.1</span>	0.7 <span style="color: blue;">0.0</span>	0.9 <span style="color: red;">↑0.2</span>	1.0 <span style="color: red;">↑0.1</span>	1.2 <span style="color: red;">↑0.2</span>
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	төгрөг	2 849 <span style="color: red;">↑6.7</span>	2 849 <span style="color: blue;">0.0</span>	3 185 <span style="color: red;">↑11.8</span>	3 469 <span style="color: red;">↑8.9</span>	3 381 <span style="color: red;">↓2.5</span>
	Юань (БНХАУ)	төгрөг	411 <span style="color: red;">↑6.7</span>	440 <span style="color: red;">↑7.1</span>	468 <span style="color: red;">↑6.4</span>	478 <span style="color: red;">↑2.1</span>	473 <span style="color: red;">↓1.0</span>
	Рубль (ОХУ)	төгрөг	39 <span style="color: red;">↓4.9</span>	39 <span style="color: blue;">0.0</span>	52 <span style="color: red;">↑33.3</span>	36 <span style="color: red;">↓30.8</span>	38 <span style="color: red;">↑5.6</span>
Хан-Уул дүүргийн төсвийн орлого		сая төгрөг	86 556.8 <span style="color: green;">↑38.2</span>	137935.0 <span style="color: green;">↑59.4</span>	260 557.3 <span style="color: green;">↑88.9</span>	390 292.2 <span style="color: green;">↑49.8</span>	648 704.9 <span style="color: green;">↑66.2</span>
Хан-Уул дүүргийн төсвийн зарлага		сая төгрөг	69 100.9 <span style="color: red;">↑30.3</span>	84 752.3 <span style="color: red;">↑22.7</span>	120 202.6 <span style="color: red;">↑41.8</span>	333 590.0 <span style="color: red;">↑2.7*</span>	692 978.4 <span style="color: red;">↑2.0*</span>
Агаарын дундаж температур		°C	16.0	15.9	14.7	17.0	18.4

Тайлбар: Өмнөх онтой харьцуулсан



Эерэг хандлага,  
өөрчлөлт

Сөрөг хандлага,  
өөрчлөлт




# ЭРҮҮЛ МЭНД, 2024 оны 9 дүгээр сар

МОНГОЛ  
УЛАС



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2023 1 722

2024 1 473

14.5%



Амаржсан эх



2023

3 737

7.5%

2024

3 458



Шинэ төрсөн хүүхэд

2023

3 762

7.1%

2024

3 495





## ЭРҮҮЛ МЭНД


Дүүргийн хэмжээнд 2024 оны эхний 9 сард 1473 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 249 хүнээр (14.5%) буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 40.9 хувийг салхин цэцэг, 11.3 хувийг гар хөл, амны өвчин, 13.0 хувийг цусан суулга, 8.7 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 5.7 хувийг тэмбүү, 3.1 хувийг заг хүйтэн, 0.6 хувийг вируст гепатит, 0.7 хувийг трихомониаз, 16.0 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

### ХҮСНЭГТ 2. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний IX сард


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	Өсөлт, бууралт 2024/2023	
					тоо/нэгж	хувь
<b>НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН</b>	<b>Бодит тоо 10000 хүнд</b>	<b>24 978 1 232.1</b>	<b>1 722 76.9</b>	<b>1 473 59.3</b>	<b>-249 -17.6</b>	<b>-14.5</b>
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	11 0.5	17 0.8	9 0.4	-8 -0.4	-47.0
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	92 4.5	165 7.4	192 7.7	27 0.3	16.4
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	8 0.4	97 4.3	58 2.3	-39 -2.0	-40.2
Сальмонеллээ	Бодит тоо 10000 хүнд	11 0.5	24 1.1	41 1.7	17 0.6	70.8
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	146 7.2	779 34.8	602 24.2	-177 -10.6	-22.7
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	1 0.0	8 0.4	31 1.2	23 0.8	3.8*
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	4 0.2	5 0.2	15 0.6	10 0.4	3.0*
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	95 4.7	348 15.5	167 6.7	-181 -8.8	-52.0
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	49 2.4	84 3.7	84 3.4	- -0.3	-
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	22 1.1	37 1.7	45 1.8	8 -0.1	21.6
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	11 0.5	10 0.4	11 0.4	1 -	10.0
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	128 6.3	124 5.5	128 5.2	4 -0.3	3.2
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	0 0	0 0	0 -	- -	-
Ковид 19	Бодит тоо 10000 хүнд	24 398 1207.8	0 0	1 -	1 -	-
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	2 0.1	24 1.1	89 3.6	65 2.5	3.7*

\*дахин

ЗУРАГ 1. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД



ЗУРАГ 2. АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД



2024 оны эхний 9 сард эхийн эндэгдэл гараагүй бол нялхсын эндэгдэл 9 хүүхдээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 хүүхдээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний IX сард

Үзүүлэлт	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	$\frac{2024}{2023}$ %
Амаржсан эхийн тоо	3 540	3 737	3 458	-7.5
Амьд төрсөн хүүхэд	3 578	3 762	3 495	-7.1
Төрөхийн улмаас эндсэн эх	3	1	0	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	28	24	33	37.5
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	7	2	6	3 дахин

Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

**Ойлголт, тодорхойлолт:**

**Амьд төрөлт:** Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

**Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох):** Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

**Эндсэн эх:** Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.






# НИЙГМИЙН ДААТГАЛ 2024 оны 9 сард

НИЙГМИЙН ДААТГАЛ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая төгрөг



\* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

## НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД

Ажилгүйдлийн таатгалын сангаас тэтгэвэр авагчид




ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авагчид



Нийт  
6 244

## ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД





## НИЙГМИЙН ДААТГАЛ

2024 оны эхний 9 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 237.1 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 238.5 тэрбум төгрөгөөр (50.2%) дутуу бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58.7 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


### ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2024 оны эхний IX сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2023 I-IX	2024 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2023 I-IX	2024 I-IX
Нийт	380 274.5	475 569.2	412 624.2	237 067.4	108.5	49.8
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	272367.4	403141.3	291892.1	203468.9	107.2	50.5
Тэтгэмжийн сангийн орлого	25056.5	35190.3	27622.6	17316.8	110.2	49.2
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	21135.9	23776.2	25581.5	2065.5	121.0	8.7
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	5311.7	13460.5	11125	14215.3	209.4	105.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	56403	0.9	56403	0.9	100.0	100.0


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 85.8 хувийг тэтгэврийн даатгалын санд, 7.3 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 0.9 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 6.0 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар хувиар



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 21930 хүнд 176.0 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3426 хүнд 18.4 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1067 хүнд 5.6 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1536 хүнд 19.4 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 8389 хүнд 3.6 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 3335 хүнд 13.1 тэрбум төгрөгийг, 620 хүнд оршуулгын тэтгэмж 1.2 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 150 хүнд 1318.6 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 16 хүнд 180.1 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 125 хүнд 270.3 сая төгрөгийг тус тус олгосон байна. Бусад зардалд 20 хүнд 49.1 сая төгрөгийг, ажилгүйдлийн тэтгэмж авсан 5933 хүнд 14.0 тэрбум төгрөг зарцуулжээ.

ЗУРАГ 5. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг



ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО



Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 86.8 хувийг тэтгэврийн, 7.2 хувийг тэтгэмжийн, 0.7 хувийг ҮОМШӨ-ний, 5.6 хувийг ажилгүйдлийн зардал эзэлж байна.

**Ойлголт, тодорхойлолт:**

**Нийгмийн даатгал** нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Нийгмийн даатгалын** сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Даатгуулагч** гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ. **Тэтгэвэр** гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

**Тэтгэмж** нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2024 оны эхний 9 сард нийгмийн халамжийн сангийн олголтын мэдээгээр нийт 20.4 хувь нь нийгмийн халамжийн сан, 72.0 хувь нь хүүхдийн мөнгө, 1.3 хувь нь алдарт эхийн одон, 1.6 нь насны хишиг, 0.5 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл, хүүхэдтэй, 3.4 хувь нь цалинтай ээж хөтөлбөр, 0.2 хувь нь хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, 0.6 хувь нь ахмад цолтон, өрх толгойлсон эцэг эх, онцгой тохиолдлын орлогод тус тус хуваарилсан байна. Харин зарлагын 72.0 хувь нь хүүхдийн мөнгө буюу нийт 100379 хүнд, 128 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 16844 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

### ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2024 оны эхний IX сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
<b>Нийгмийн халамжийн сангийн орлого</b>	<b>121 387.6</b>	
Улсын төсвийн санхүүжилтийн орлого	121 387.6	
Нийгмийн халамжийн сан	24 739.8	
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	618.2	
Алдарт эхийн одонгийн тусламж	1 543.3	
Насны хишиг	1 988.2	
Хүүхдийн мөнгө	87 396.9	
Цалинтай ээж хөтөлбөр	4 198.0	
Ахмад цолтон ахмадын хөнгөлөлт, тусламж	64.9	
Өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	615.4	
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	22.8	
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	200.1	
<b>Зарлагын нийт дүн</b>	<b>121 387.6</b>	<b>170 286</b>
Нийгмийн халамжийн сан	24 739.8	24 714
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	5 431.6	16 844
Алдарт эхийн одонгийн тусламж	1 543.3	13 052
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	64.9	128
Хүүхдийн мөнгө	87 396.9	100 379
Насны хишиг	1 988.2	13 204
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	22.8	19
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	200.1	1 946

**Ойлголт, тодорхойлолт:**

**Нийгмийн халамж** гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

**Нийгмийн халамжийн дэмжлэг**, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.



## ГЭМТ ХЭРЭГ, 2024 оны эхний 9 сард

ᠮᠤᠩᠭᠠᠨ  
ᠠᠭᠤᠯᠠ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг, нийслэл

2023 I-IX


19 491

2024 I-IX

22 941

17.7% ↑

Дүүргээр



↓ ↑ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

2727



Гэмтсэн хүн

460



Нас барсан хүн

43



## ГЭМТ ХЭРЭГ

2024 оны 9-р сарын байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт 3521 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 626 хэргээр 21.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр


Төрөл	2023 I-IX	2024 I-IX	Үүнээс: Цагдаагийн хэлтсээр		Өсөлт, бууралт	
			I	II	Тоо	Хувь
Нийт	2 895	3 521	2 234	1 287	626	21.6

### ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, эхний IX сарын байдлаар

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2024/2023	
	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	Тоо	Хувь
<b>Дүүргийн дүн</b>	<b>2 520</b>	<b>2 895</b>	<b>3 521</b>	<b>589</b>	<b>26.8</b>
Хүнийг алах /10.1/	13	11	10	- 1	90.9
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх /10.4/	18	29	47	18	62.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/	539	450	434	-16	96.4
Хүчиндэх /12.1/	36	27	30	3	11.1
Хулгайлах /17.1/	539	418	779	361	86.3
Дээрэмдэх /17.2/	20	13	35	22	2.6*
Залилах /17.3/	890	1 452	1 441	- 11	99.2
Малын хулгай	14	10	1	- 9	10.0
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах /20.16/	5	-	-	-	-
ХАБТХАЖЭ* /27.1-27.11/	79	83	134	51	1.6*
Бусад	367	402	610	209	1.5*

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 12.3 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бол 40.9 хувийг залилах, 22.1 хувийг хулгайлах, 3.8 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих, 0.9 хувийг хүчиндэх, 1.0 хувийг дээрэм, 0.3 хувийг хүнийг алах, 1.3 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 17.3 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэг	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2023-2024	
	2022 I-IX	2023 I-IX	2024 I-IX	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	19 321	19 491	22 941	1 771	17.7
Хан-Уул	2 232	2 895	3 521	626	21.6
Үүнээс: Цагдаагийн хэлтсээр					
I хэлтэс	1 297	1 772	2 234	462	126.1
II хэлтэс	935	1 123	1 287	164	114.6
Нийслэлийн дүнд эзлэх хувь	11.6	14.9	15.3	0.4	2.7

Дүүргийн хэмжээнд 2024 оны 9-р сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нийслэлийн дүнд эзлэх хувь 15.3 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 пунктээр өссөн байна. Түүнчлэн дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 63.4 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

ХҮСНЭГТ 9. ЗӨРЧИЛ-ийн мэдээ, хэлтсээр

Хэлтэс	Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг		Эмэгтэй хүн оролцсон		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	
	2023 I-IX	2024 I-IX	2023 I-IX	2024 I-IX	2023 I-IX	2024 I-IX
Цагдаагийн I	104	116	248	195	27	43
Цагдаагийн II	89	108	124	92	29	50
Нийт	193	224	372	287	56	83

Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2024 оны 9-р сард 83 нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн бол өмнөх онтой харьцуулахад 27 (48.2%)-иар өссөн, дүүргийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон 2727 иргэн хохирсоны 1229 (45.1%) нь эмэгтэйчүүд байсан бол 9 (0.3%) нь 7 хүртэлх насны хүүхэд, 40 (1.5%) нь 8-13 насны хүүхэд, 90 (3.3%) нь 14-17 насны хүүхдүүд хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас 460 хүн гэмтэж осолдон, 43 хүн нас барж, төр ард иргэдэд 80212.4 сая



төгрөгийн хохирол учруулсны 38225.2 (47.7%) сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. 2024 оны 9-р сарын байдлаар тус дүүргийн 15 дугаар хороонд 457 гэмт хэрэг гарч хамгийн өндөр байхад 7 хорооны нутаг дэвсгэрт хамгийн бага буюу 21 хэрэг гарсан байна

**Ойлголт, тодорхойлолт:**

**Гэмт хэрэг:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

**16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг:** Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

**Хохирогч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

**Гэмт хэргийн хохирол:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

**Яллагдагч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

“Хан-Уул дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2024 оны IX сарын танилцуулга


ХҮСНЭГТ 10. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, төрлөөр

Хороод	Нийт дүн	Хүнийг алах /10.1/	Хүнийг амиа хорлох нөхцөлд байдалд хүргэх /10.4/	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг /11.1-11.7/	Хүчиндэх /12.1/	Хулгайлах /17.1/	Үүнээс			Дээрэмдэх /17.2/	Залилан мэхлэх /17.3/	Малын хулгай /17.2/	Олон нийтийн амгалан тайван байдал /20.1-20.17/	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг /27.1-27.11/	Бусад
							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай						
1-р хороо	156	-		14	1	31	19	-	11	1	64		-	6	39
2-р хороо	176	3		19	1	32	26	-	4	2	81		-	6	32
3-р хороо	275	1	1	38	6	42	33	-	6	2	114		-	13	58
4-р хороо	149	-	1	17	2	36	25	-	7	2	53		-	10	28
5-р хороо	34	1		3		7	5	-	2	1	13		-	2	7
6-р хороо	53	-	2	8	1	14	10	-	2	3	17		-	2	6
7-р хороо	21	-	3	4	1	5	2	-	1		5		-	2	1
8-р хороо	116	-	4	17	1	23	15	1	4	1	37		-	11	22
9-р хороо	60	-	1	15	3	12	9	-	1		18		-	2	9
10-р хороо	84	-	2	16	1	13	12	-		1	36		-	8	7
11-р хороо	254	1-	3	31		49	39	1	6	1	99		-	10	60
12-р хороо	52	-	5	7	1	15	9	-	1	1	13		-	2	8
13-р хороо	34	1	4	7		4	3	-	1		8	1	-	5	4
14-р хороо	68	2	3	11	2	11	8	1		1	15		-	6	17
15-р хороо	457	-	3	67	1	135	106	-	24	6	147		-	15	83
16-р хороо	89	-	1	14	1	26	20	1	3	1	28		-	6	12
17-р хороо	159	1	2	15		46	42	-	1	3	64		-	5	23
18-р хороо	191	-	1	17		65	58	-	5	1	77		-	1	29
19-р хороо	120	-	1	19	2	28	23	-	4	2	48		-	3	17
20-р хороо	396	-	3	35	1	28	24	-	2	2	255		-	3	69
21-р хороо	151	-		13	2	39	32	-	6	2	69		-	6	20
22-р хороо	50	-		6	1	19	13	-		1	16		-	1	6
23-р хороо	126	-	1	15		26	26	-		1	58		-	3	22
24-р хороо	165	-	4	18	2	50	40	-	10		66		-	4	21
25-р хороо	85	-	2	8		23	18	-	4		40		-	2	10
<b>Нийт дүн</b>	<b>3 521</b>	<b>10</b>	<b>47</b>	<b>434</b>	<b>30</b>	<b>779</b>	<b>617</b>	<b>4</b>	<b>105</b>	<b>35</b>	<b>1441</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>134</b>	<b>610</b>




## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2024 оны 9 дүгээр сард, тэрбум төгрөг


ᠬᠠᠨᠬᠡᠭᠣᠯ



### Хан-Уул дүүргийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын бүтэц



■ Татварын орлого  
■ Татварын бус орлого




■ Урсгал зардал  
■ Хөрөнгийн зардал



## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2024 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 648.7 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 79.5 (12.2%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2023 оноос 66.2 хувь өссөн байна. Төсвийн нийт орлогын 48.7 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 51.3 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

ЗУРАГ 8. ТӨСВИЙН ОРЛОГО, сая төг



Татварын орлогын хэмжээ 315.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 44.4 тэрбум төгрөгөөр (12.3%), татварын бус орлого 332.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 35.1 тэрбум төгрөгөөр (9.5%) тус тус дутуу бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 11. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2024 оны эхний IX сард, сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ хувь	Зөрүү
Орон нутгийн орлого	728 243.4	648 704.9	89.1	-79 538.5
1.Татварын орлогын дүн	360 166.4	315 777.1	87.7	-44 389.3
1.1 Орлогын албан татвар	279 081.8	262 580.4	94.1	-16 501.4
Хувь хүний орлогын албан татвар	279 081.8	262 580.4	94.1	-16 501.4
1.2 Хөрөнгийн албан татвар	19 496.2	17 975.1	92.2	-1 521.1
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж	61 588.4	35 221.6	57.2	-26 366.8
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	33 358.8	11 714.3	35.1	-21 644.5
Улсын тэмдэгтийн хураамж	31 008.0	9 625.5	31.0	-21 382.5
Ашигт малтмал ашигласны төлбөр	124.0	176.0	141.9	52.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2 226.8	1 912.8	85.9	-314.0
1.3.2 Газрын төлбөр	28 198.8	23 456.1	83.2	-4 742.7
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	30.8	51.2	165.9	20.3
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	30.8	51.2	165.9	20.3
2.Татварын бус орлогын дүн	368 077.0	333 927.8	90.4	-35 149.3
2.1 Нийтлэг бус татварын орлого	2 812.2	4 293.4	152.7	1 481.2
Торгуулийн орлого	2 280.0	3 949.5	173.2	1 669.5
Төсөвт байгууллагын өөрийн орлого*	501.6	322.2	64.2	-179.3
Бусад орлого	30.6	21.7	74.8	-8.9
2.2 Тусламжийн орлого	363 019.7	326 697.1	90.0	-36 322.6
2.3 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2 245.1	1 937.3	86.3	-307.8

Тайлбар: Төсөвт байгууллагын өөрийн орлого нь үндсэн болон туслах орлогын нийлбэр дүн


ХҮСНЭГТ 12. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2024 оны эхний IX сард, сая.төг

Төсвийн орлого			Үүнээс:						
Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого			
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	
Дүн	644 704.9	89.1	-79 538.5	315 777.1	87.7	-44 389.3	333 927.8	90.4	-35 149.3

Орлогын албан татвар төлөвлөснөөс 16.5 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 1.5 тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 26.4 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

Төсвийн нийт зарлагын 1.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.2 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 98.5 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

ЗУРАГ 9. ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төг



2024 оны эхний 9 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 692.9 тэрбум төгрөгийн (89.6%) зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 80.6 тэрбум төгрөгийг (10.4%) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

ХҮСНЭГТ 13. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2024 оны эхний IX сард, сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	644 704.9	773 579.5	692 978.4	89.6	-80 601.1	-48 273.5

ХҮСНЭГТ 14. ӨГЛӨГ, 2024 оны эхний IX сард, сая.төг

	9-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	9-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	1.1	-	1.1	-

**Ойлголт, тодорхойлолт:**

**Татварын орлого:** Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

**Татварын бус орлого:** Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

**Төсвийн орлого:** Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.


**Урсгал зардал:** Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өслөө. 2024 оны 09 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад 5.2 хувь өссөн ба өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



ХҮСНЭГТ 15. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2023-IX 2022-IX	2024-IX 2023-IX	2024-IX 2023-XII	2024-IX 2024-VIII
<b>Ерөнхий индекс</b>	<b>110.2</b>	<b>106.5</b>	<b>105.2</b>	<b>100.1</b>
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	116.8	106.9	106.0	99.1
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.1	104.0	101.6	100.5
Хувцас, бөс бараа, гутал	108.6	109.4	106.2	101.7
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	104.9	108.1	104.7	100.3
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	107.2	109.5	107.8	100.8
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	108.4	104.4	103.8	100.0
Тээвэр	100.2	99.6	98.8	99.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	101.0	102.2	102.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	105.5	104.9	104.9	100.5
Боловсролын үйлчилгээ	121.2	119.7	119.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	119.0	107.5	107.5	103.1
Даатгал, Санхүүгийн үйлчилгээ	102.8	102.3	102.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	128.6	110.4	108.2	101.6

2024 оны 09 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 405 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 46.7 хувь нь өсөж, 19.2 хувь нь буурч, 34.1 хувь нь тогтвортой байв.

ХҮСНЭГТ 16 . УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН САРЫН ИНДЕКС, /**эерэг, сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт хувь	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	<b>0.9</b>	Энэ бүлгийн үнийн бууралтад гурил болон бусад төстэй бүтээгдэхүүний үнэ 2.0 хувиар, адууны махны үнэ 2.3 хувиар, мандарин 3.5 хувиар, усан үзэм 8.2 хувиар, хатаасан жимс 4.2 хувиар, навчит болон ишт хүнсний ногооны үнэ 4.3 хувиар, төмсний үнэ 29.8 хувиар, бусад хүнсний ногооны үнэ 12.0 хувиар, төмсний үнэ 14.4 хувиар, жимс ногооны шүүс 1.4 хувиар, тус тус буурсан нь нөлөөлөв.
Согууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	<b>0.5</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд бусад дарс 4.8 хувиар, шар айраг 5.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв
Хувцас, бөс бараа, гутал	<b>1.7</b>	Энэ бүлгийн өсөлтөд Хөвөн, бөс барааны үнэ 3.9 хувиар, эмэгтэй бэлэн хувцасны үнэ 2.2 хувиар, хүүхдийн бэлэн хувцасны үнэ 3.2 хувиар, жижиг эдлэл, хэрэгслийн үнэ 2.2 хувиар, эрэгтэй гуталны үнэ 1.9 хувиар, гутал засвар, түрээсийн үнэ 2.3 хувиар өссөн нь нөлөөлөв.
Орон сууц, ус цахилгаан хийн болон бусад түлш	<b>0.3</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд орон сууцны урсгал засварын барааны үнэ 0.6 хувиар, хатуу түлшний үнэ 0.6 хувиар өссөн нь нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	<b>0.8</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хивс болон шалны бусад дэвсгэрийн үнэ 1.0 хувиар, гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэлийн үнэ 1.3 хувиар, угаалгын машин, хатаагч машины үнэ 1.1 хувиар, цэвэрлэгээний зориулттай гэр ахуйн цахилгаан хэрэгслийн үнэ 1.7 хувиар, шилэн сав суулгын үнэ 4.9 хувиар, хутга болон бусад иртэй гал тогооны хэрэгслийн үнэ 14.9 хувиар, Гэр ахуйн үйлчилгээний үнэ 5.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Тээвэр	<b>0.5</b>	Энэ бүлгийн үнийн бууралтад хувийн тээврийн хэрэгслийн шатах, тослох материалын үнэ 1.7 хувиар буурсан нь нөлөөлөв.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	<b>0.5</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд соёлын бусад үйлчилгээний үнэ 3.8 хувиар, бичгийн болон зургийн хэрэгслийн үнэ 1.5 хувиар өссөн нь нөлөөлөв.
Зочид буудал, нийтийн хоол дотуур байрны үйлчилгээ	<b>3.1</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд ресторан, кафе, бусад зоогийн газрын үнэ 4.5 хувиар, гуанз, цайны газрын үнэ 0.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Бусад бараа үйлчилгээ	<b>1.6</b>	Энэ бүлгийн үнийн өсөлтөд гоо сайхны хэрэгцээнд зориулсан бүтээгдэхүүний үнэ 2.1 хувиар, цүнх, чемодан, түрүүвчийн үнэ 0.4 хувиар, хувь хүний бусад эд зүйл, хэрэглэлийн үнэ 3.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

2024 оны 9 дугаар сарын 16 -ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад “ Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 390 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 150 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 270 төгрөг, хонины ястай мах 1200, үхрийн мах” ястай 1500 төгрөг, цагаан будаа 1800 төгрөг, задгай сүү 800 төгрөгөөр тус тус өссөн байна. Төмс 400 төгрөг, лууван 300 төгрөг, манжин 4000 төгрөг, сонгино 500 төгрөгөөр тус тус буурсан. Харин “ Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ, элсэн чихэр, байцай, польш алим, “Сүү” ХК-ийн цөцгийтэй тарагны үнэ тогтвортой байлаа.




ХҮСНЭГТ 17. БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн IX сард

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2023.IX	2024.IX	$\frac{2024}{2023}\%$
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	2 400	2 400	0.0
Хонины мах, ястай	Кг	10 800	12 000	11.1
Үхрийн мах, ястай	Кг	14 500	16 000	10.3
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	2 850	3 240	13.7
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	2 490	2 640	6.0
Гурил ,2-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1 560	1 830	17.3
Элсэн чихэр	Кг	4 500	4 500	0.0
Төмс, монгол	Кг	1 500	1 100	-26.7
Байцаа, монгол	Кг	2 000	2 000	0.0
Лууван, монгол	Кг	3 800	3 500	-7.9
Манжин, монгол	Кг	6 500	2 500	-61.5
Сонгино, хятад	Кг	3 500	3 000	-14.3
Цагаан будаа	Кг	4 300	6 100	41.9
Алим, Польш	Кг	8 000	8 000	0.0
Сүү, задгай	литр	2 800	3 600	28.6
Тараг, цэцгийтэй, “Сүү” ХК	литр	4 140	4 140	0.0


\*-дахин

Тайлбар: Худалдаа үйлчилгээний “Мөнхсуврага” төв

ЗУРАГ 11. НЭГ КГ ХОНИНЫ МАХНЫ дундаж үнэ, төгрөг



ЗУРАГ 12. НЭГ КГ ҮХРИЙН МАНХНЫ дундаж үнэ, төгрөг



ЗУРАГ 13. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IX сард, төгрөг





ЗУРАГ 14 . НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IX сард, төгрөг



ХҮСНЭГТ 18. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2023.X.02					2024.IX.30				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Петровис	3 710	2 370	2 390	3 490	-	3 910	2 370	2 390	3 390	-
Магнай трейд	3 710	-	2 390	3 490	-	3 910	-	2 390	3 390	-
Сод монгол	3 710	2 315	2 390	3 490	-	3 910	2 315	2 390	3 390	-
Шунхлай	3 710	2 350	2 390	3 490	-	3 910	2 350	2 390	3 390	-
Юнигаз	-	-	-	-	1 790	-	-	-	-	1 790
Дундаж үнэ	3 710	2 345	2 390	3 470	1 790	3 910	2 345	2 390	3 390	1 790

Эх сурвалж: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 9-р сарын мэдээ

**Ойлголт, тодорхойлолт:**

**Хэрэглээний сагс:** Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

**Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:** Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

**Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):** Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left( \frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left( \frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left( \frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left( \frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

$I_{ct}^L$  – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс  
 t – Тайлант үе  
 0 – суурь үе  
 $P_t^i$  – i барааны тайлант үеийн үнэ  
 $P_0^i$  – i барааны тайлант үеийн үнэ  
 $Q_0^i$  – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.



# АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2024 оны эхний 9 дүгээр сард


Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг

Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг


Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг


Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг




Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг






## АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн байгууллагууд 2024 оны эхний 9 сард 1432.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1677.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 25.0 хувиар өсч, борлуулалт 1.2 хувиар буурсан байна.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр



Боловсруулах аж үйлдвэрийн салбарт цагаан архи өмнөх оны мөн үеэс 76 хувиар, бусад гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 0.1-67.1 хувиар өссөн байна. Харин талх 49.8 хувиар, бусад гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн биет хэмжээ 7.9-52.8 тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 19. АЖ ҮЙЛДВЭРИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2023 I-IX	2024 I-IX	$\frac{2024 \text{ I-IX}}{2023 \text{ I-IX}}$
Боловсруулах аж үйлдвэр				
Малын мах	тн	240.4	113.4	-52.8
Өлөн гэдэс	мян.гогцоо	17.6	29.4	67.1
Боловсруулсан шингэн сүү	мян.л	22 531.5	20 750.4	-7.9
Талх	тн	4 327.0	2 174.5	-49.8
Нарийн боов	тн	3 015.3	2 361.7	-21.7
Цагаан архи	мян.л	10 625.6	18 702.6	76.0
Соёолжоор бэлтгэсэн шар айраг	мян.л	51 062.2	51 130.9	0.1
Самнасан ноолуур	тн	331.1	209.3	36.8
Хивс, шалны нэхмэл дэвсгэр	мян.м2	32.5	35.9	10.5
Сүлжмэл эдлэл-ноолуур	мян.ш	109.7	60.7	-44.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж				
Цахилгаан эрчим хүч	мян.квт.цаг	663 119.1	664 967.3	0.3
Дулааны эрчим хүч	мян.гкал	1 518.7	1 609.6	6.0

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 9 сарын

гүйцэтгэлээр 10535.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.3 (41.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1301.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 287.6 (28.4%) тэрбум төгрөгөөр өсөхөд, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 5.2 (5.1) тэрбум төгрөгөөр, малын тэжээл үйлдвэрлэл 2.6 (61.2%) тэрбум төгрөгөөр, ундаа үйлдвэрлэл 215,9(69.2%) тэрбум төгрөгөөр, ээрэх, нэхэх, даавуун материал үйлдвэрлэл 14.5(8.3%) тэрбум төгрөгөөр, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 64.5 (87.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл 6.4(14.3%) тэрбум төгрөгөөр, хувцас үйлдвэрлэл 8.9(6.0%)тэрбум төгрөгөөр, мах боловсруулах, консервлох үйлдвэрлэл 663 (16.4%) сая төгрөгөөр, хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа 2.1 (11.4%) тэрбум төгрөгөөр, резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл 4.1 (49.4%) тэрбум төгрөгөөр, жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт 5.8 (0.1) тэрбум төгрөгөөр, арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 0.6 (3.7%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Цахилгаан, хий, уур, агааржуулалт 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 114.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.9 (4.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 5.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1071.6 (22.8%) сая төгрөгөөр өссөн байна.

Дүүргийн аж үйлдвэрийн салбар 2024 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1104.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 0.7 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 90.9 хувийг, цахилгаан, хий, уур, агааржуулалт 8.0 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 0.4 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 20. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, оны үнээр, сая төгрөгөөр

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2023 I-IX*	2024 I-IX	<u>2024</u> 2023
	сая төгрөг		
<b>БҮГД</b>	<b>1 145 902.4</b>	<b>1 432 154.6</b>	25.0
<b>УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>	17 916.8	10 535.3	-41.2
Бусад ашигт малтмал олборлолт	17 916.8	10 535.3	-41.2
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ</b>	1 013 978.6	1 301 635.9	28.4
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	474 955.7	691 753.1	45.6
Мах боловсруулах, консервлох	4 033.1	3 369.8	-16.4
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	5 455.9	5 450.1	-0.1
Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	104 038.0	109 333.8	5.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	44 891.2	38 456.3	-14.3
Малын тэжээл үйлдвэрлэл	4 288.9	6 914.9	61.2
Ундаа үйлдвэрлэл	312 248.7	528 228.2	69.2
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	175 484.6	190 007.7	8.3
Хувцас үйлдвэрлэл	150 537.7	141 579.5	-6.0
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	15 402.8	14 837.9	-3.7
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	25 251.3	23 712.4	-6.1
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	18 256.1	16 173.7	-11.4
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	73 849.7	138 354.8	87.3
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	21 870.1	30 743.0	40.6
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 197.5	4 146.4	-49.4
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	17 573.6	16 571.0	-5.7
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11 452.1	8 481.2	-25.9
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.5	0.0	-100.0
Тавилга үйлдвэрлэл	4 707.4	3 815.9	-18.9
Бусад боловсруулах үйлдвэрлэл	13 550.7	16 363.2	20.8
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	2 867.7	5 096.0	77.7
<b>ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ</b>	109 310.0	114 214.8	4.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	109 310.0	114 214.8	4.5
<b>УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	4 697.0	5 768.6	22.8
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	4 697.0	5 768.6	22.8

\*дахин их

Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 1677.1 тэрбум төгрөгийг дотоодод, 208.3 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 12.4 хувийг экспортод гаргасан бөгөөд ээрэх нэхэх даавуун материал бэлтгэх үйлдвэрлэлийн 81.8 хувь, нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэлийн 25.5 хувь, ундаа үйлдвэрлэлийн 0.5 хувь, мах боловсруулах үйлдвэрлэл 2.5 хувь, бусад ашигт малтмал олборлолт 2.3 хувь, машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн 7.2 хувийг тус тус гадаад борлуулсан байна.

ХҮСНЭГТ 21. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, салбараар, оны үнээр, сая төгрөгөөр

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2023 I-IX	2024 I-IX	<u>2024</u> 2023	Үүнээс: Экспорт (хувиар)
	сая төгрөг			
<b>БҮГД</b>	<b>1 701 503.6</b>	<b>1 677 106.2</b>	-1.4	<b>12.4</b>
<b>УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>	17 916.8	10 605.6	-40.8	
Бусад ашигт малтмал олборлолт	17 916.8	10 605.6	-40.8	2.3
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ</b>	1567 502.5	1546 214.3	-1.4	13.4
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	997 266.3	889 779.1	-10.8	0.4
Мах боловсруулах, консервлох	4 811.9	6 352.3	32.0	2.5
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	5 372.3	5 232.9	-2.6	
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	156 523.9	161 818.7	3.4	
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	46 338.5	61 314.6	32.3	
Малын тэжээл үйлдвэрлэл	4 288.9	6 971.6	62.6	
Ундаа үйлдвэрлэл	779 930.9	648 088.9	-16.9	0.6
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	177 320.8	193 090.9	8.9	81.8
Хувцас үйлдвэрлэл	164 443.9	171 356.5	4.2	25.5
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	14 757.7	17 387.8	17.8	
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	25 406.7	24 434.0	-3.8	
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	28 629.1	24 088.7	-15.9	
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	73 966.6	139 104.7	88.1	
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	26 017.6	29 785.9	14.5	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 566.5	4 601.6	-46.3	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	18 264.0	16 505.3	-9.6	
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11 365.9	10 361.9	-8.8	7.2
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.5	0.0	-	100.0
Тавилга үйлдвэрлэл	4 721.3	4 273.4	-9.5	
Бусад боловсруулах үйлдвэрлэл	13 741.2	16 348.6	19.0	
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	3 013.5	5 096.0	69.1	
<b>ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ</b>	109 310.0	114 214.5	4.5	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	109 310.0	114 214.5	4.5	
<b>УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	6 774.3	6 071.8	-10.4	
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	6 774.3	6 071.8	-10.4	

\*дахин их



**Ойлголт, тодорхойлолт:**

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

**Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал:** НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

## ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2024 оны эхний 9 сард Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 3610 өргөдөл, гомдол ирснээс хуулийн дагуу хугацаанд нь 3489 өргөдөл өгч, шийдвэрлэх хугацаа болоогүй гомдолд хариу 118, шийдвэрлэх хугацаа хэтэрсэн 3 өргөдөл байна.











### ХҮСНЭГТ 22. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ-ЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга					Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим	Хүсэлт	Гомдол	Талархал	Санал	Мэдэгдэл			
Удирдлага	1	-	1	-	-	1	-	-	-	-	-	1	-
ТЗУХ	43	-	4	38	1	8	31	3	1	-	42	1	-
СТСХ	10	-	2	8		2	7	-	1	-	10	-	-
ТГУХ	54	-	10	39	5	28	20	-	6	-	52	2	-
НБХ	21	-	14	7	-	15	3	2	1	-	21	-	-
ТНБХХУХ	359	-	35	309	15	132	209	1	16	1	346	13	-
ХХҮХ	233	-	8	220	5	57	164	-	12		226	7	-
ХЭЗАХ	27	-	17	8	2	17	8	-	1	1	24	3	-
Цэргийн штаб	53	-	53	-	-	53	-	-	-	-	53	-	-
<b>ЗДТГ-ын дүн</b>	<b>801</b>	0	144	629	28	313	442	6	38	2	774	27	-
Албан бус- НТБ төв	9	-	9	-	-	9	-	-	-	-	9	-	-
Биеийн тамир, спортын хороо	1	-	-	1	-	1	-	-	-	-	1	-	-
Боловсролын хэлтэс	245	-	10	234	1	33	176	26	10	-	203	40	2
Газрын алба	1 007	-	713	281	13	801	198	-	8	-	982	24	1
ГБХЗХХ	66	-	64	2	-	55	4	1	6	-	63	3	-
НДХ	268	-	41	227	-	47	214	6	1	-	263	5	-
Онцгой байдлын хэлтэс	20	-	1	15	4	12	8	-	-	-	19	1	-
Татварын хэлтэс	500	-	480	19	1	477	21	1	1	-	500	-	-
Цагдаагийн газар	306	-	2	299	5	22	206	77	1	-	293	13	-
ХөХҮХ	296	-	213	80	3	212	76	4	4	-	291	5	-
УБХ	77	-	7	69	1	16	48	8	5	-	77	-	-
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	11	-	10	1	-	11	-	-	-	-	11	-	-
Соёлын ордон	1	-	-	1	-	-	1	-	-	-	1	-	-
Усан спорт сургалтын төв	2	-	-	2	-	-	2	-	-	-	2	-	-
<b>Дэргэдэх хэлтэс, албадын дүн</b>	<b>2 809</b>	0	1 550	1 231	28	1 696	954	123	36	0	2 715	91	3
<b>Нийт дүн</b>	<b>3 610</b>	0	1 694	1 860	56	2 009	1 396	129	74	2	3 489	118	3

Танилцуулгыг хянасан:

О.Гэрэл  
Б.Тодмаа

Танилцуулгыг бэлтгэсэн:

- Ц.Энх-Оюун    Газар тариалан, хөдөө аж ахуй, эрүүл мэнд
- Ж.Энх-Амгалан    Хан-Уул дүүргийн төсөв, барилга, нийгмийн даатгал
- Б.Тодмаа   Аж үйлдвэр, гэмт хэрэг,  
инфографик мэдээлэл, хавтасны дизайн
- Б.Тодмаа   Хэрэглээний үнэ, нийгмийн халамж

Танилцуулгыг нэгтгэсэн:

Б.Тодмаа